



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 09 сарын 11 өдөр

Дугаар 255

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 22 дугаар зүйлийн 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.5, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 08 дугаар тогтоолоор баталсан “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам”-ын 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эм Ай Ди Эй Эс” ХХК-д үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосугай.

2. Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосонтой холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Эм Ай Ди Эй Эс” ХХК /Я.Дашдорж/-д үүрэг болгосугай.

1/ Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг дээдлэн, хөрөнгө оруулалтын менежментийн компанийн мэргэжлийн үйл ажиллагааны болон ажилтны ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллах;

2/ Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдуулан зохих өөрчлөлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэх;

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН